



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/18

Өвт

Тамхи худалдах тусгай зөвшөөрөл
сунгах тухай


Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 7.3 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 16 дугаар зүйлийн 16.3.4, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Б.Бандансанги эзэнтэй "Урьхан", Ж.Гансугар эзэнтэй "Хангайн овоо" хүнсний дэлгүүрүүдэд тамхи худалдах тусгай зөвшөөрлийн хугацааг 2 жилийн хугацаатай сунгасугай.

2. Тамхи худалдаалах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамж 100000 (Нэг зуун мянган) төгрөгийг сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэхийг Гааль, татварын улсын байцаагч (Н.Батсайхан)-д даалгасугай.

3. Тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгогдсон дэлгүүрийн үйл ажиллагаанд хяналт тавьж үр дүнг тооцон ажиллахыг Цагдаагийн хэсгийн дарга, Цагдаагийн ахмад (Д.Энх-Амгалан), Гааль, татварын улсын байцаагч (Н.Батсайхан), Мал эмнэлгийн улсын байцаагч (П.Аюушжав) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН